

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД 2022 ОНД ИРГЭДЭЭС ГАРГАСАН САНАЛ, ХҮСЭЛТ, ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ

1. Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын удирдах албан тушаалтанд 2022 оны эхний хагас жилд иргэд, байгууллагаас 12061 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6667 нэгжээр буюу 123.6 хувиар өссөн бол нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 333 буюу 2.8 хувь нь санал, 11634 буюу 96.5 хувь нь өргөдөл, 94 буюу 0.8 хувь нь гомдол байна.

Нийт санал, өргөдөл, гомдлын 688 буюу 5.7 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 181 буюу 1.5 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1770 буюу 14.7 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 1783 буюу 14.8 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 287 буюу 2.4 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 7352 буюу 60.9 хувь нь бусад өргөдөл гомдол байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 11943 буюу 99.0 хувийг шийдвэрлэж, 118 буюу 1.0 хувьд нь хуулийн хугацаанд шалгалтын ажиллагаа явуулж байна.

2. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллага, алба хаагчдаас 293 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34 нэгж буюу 13.1 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 1 буюу 0.3 хувь нь санал, 277 буюу 94.5 хувь нь өргөдөл, 15 буюу 5.1 хувь нь гомдол байгаа бол 18 буюу 6.1 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 28 буюу 9.5 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 60 буюу 20.5 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 5 буюу 1.7 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 45 буюу 15.4 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 137 буюу 46.7 хувь нь бусад өргөдөл гомдол байна. Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 281 буюу 95.9 хувийг шийдвэрлэж, 12 буюу 4.1 хувийг хуулийн хугацаанд судалж байна.

3. 2022 оны эхний хагас жилд иргэдээс Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 136 санал хүсэлт, гомдол, шүүмжлэл, талархал, ирүүлсний 18 буюу 13.2 хувь нь санал хүсэлт, 88 буюу 64.7 хувь нь гомдол, 16 буюу 11.8 хувь нь хүсэлт, 14 буюу 10.3 хувь нь талархал байна.

Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, шүүмжлэл, талархлын 117 буюу 86.0 хувийг шийдвэрлэж, 19 буюу 14.0 хувьд холбогдох алба, нэгж хуулийн хугацаанд шалгалтын ажиллагаа явуулж байна.

4. Энэ хугацаанд иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 1112 өргөдөл, гомдол ирүүлж, 1309 алба хаагчийг холбогдуулан шалгасан ба урьд оны мөн үетэй харьцуулбал өргөдөл, гомдол 227 буюу 25.6 хувь, шалгагдсан алба хаагч 317 буюу 32.0 хувиар тус тус өссөн байна.

Өргөдөл, гомдлын **31 буюу 2.8** хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэх саналтай холбогдох байгууллагад шилжүүлж, **264 буюу 25.7** хувьд нь сахилгын шийтгэл

оногдуулж, **736 буюу 66.2** хувьд цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй, **46 буюу 4.1** хувьд алба хаагчийн буруутай үйл ажиллагаа нотлогдсон боловч хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл оногдуулах хугацаа өнгөрсөн үндэслэлээр хаасан байна.

Нийт өргөдөл, гомдлын 1030 буюу 92.6 хувийг шийдвэрлэж, 82 буюу 7.4 хувь нь хуулийн хугацаанд шалгагдаж байна.

ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС